

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/181/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)  
Аудитор: Д.Отгонбаяр  
Утас: 89306788 Цахим хаяг: [munkh-orgill@audit.gov.mn](mailto:munkh-orgill@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.13 № 01/243  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА  
Л.ЮМЖИРДУЛАМ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор үндсэн цалин нэмэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад цалингийн сан 63.2 хувиар өссөн байна.

#### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэл тайлагнал, төсвийн зарцуулалттай холбоотой алдаа, зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга нь 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 56 арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргаар батлуулж 95 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлж ажилласан байна.

6724040574

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөгөөр/**

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,256,016.5	17,406,587.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,673,352.6	14,190,493.4
33	АВЛАГА	4,566,748.2	3,182,489.8
35	БАРАА МАТЕРИАЛ	15,915.7	33,604.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	588,903.2	536,538.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	588,903.2	536,538.5
39200	Биет хөрөнгө	538,153.8	485,531.8
39300	Биет бус хөрөнгө	50,749.4	51,006.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,844,919.7	17,943,125.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	238,191.2	1,118,046.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	238,191.2	1,118,046.4
41300	Өглөг	76,017.1	360,369.7
41400	Урьдчилж орсон орлого	162,174.1	757,676.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,606,728.4	16,825,079.5
51	Засгийн газрын хувь оролцоо	16,606,728.4	16,825,079.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	287,580.0	287,580.0
51200	Хуримтлагдсан үр дүн	16,208,401.2	16,426,752.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,747.2	110,747.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,844,919.7	17,943,125.9

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/**

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	147,397,778.5	164,879,883.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,592,712.4	51,939,099.7
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	40,592,712.4	51,939,099.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,555.0	187,631.4
120	Нийтлэг татварын бус орлого	176,555.0	187,631.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,628,511.1	112,753,152.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	145,507,571.3	164,661,532.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,507,571.3	164,661,532.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,894.3	1,404,919.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,061.2	1,106,921.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,482.4	138,819.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,840.9	30,908.9
2104	Хангамж, бараа материалын зардал	25,123.5	23,862.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,785.7	1,376.2
2107	Томилот, зочны зардал	2,996.5	15,811.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,696.6	28,744.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,907.5	58,475.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,597,677.1	163,256,613.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,890,207.2	218,351.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,890,207.2	218,351.1

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	148,871,172.7	167,055,189.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,179,365.7	51,533,288.3
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	40,179,365.7	51,533,288.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	421,241.0	389,761.3
120	Нийтлэг татварын бус орлого	421,241.0	389,761.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	108,270,566.0	115,132,140.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145,864,684.6	164,538,049.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,864,684.6	164,538,049.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	878,431.7	1,364,694.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,061.2	1,106,921.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,482.4	138,819.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,315.8	31,434.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,083.8	39,327.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,454.7	1,220.0
2107	Томилолт, зочны зардал	2,996.5	15,811.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,053.9	26,776.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,983.3	4,385.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,986,252.9	163,173,354.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,006,488.2	2,517,140.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,006,488.2	2,517,140.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,666,864.5	11,673,352.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,673,352.6	14,190,493.4

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,721,544.7	0.0	14,721,544.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-5,023.5	0.0	-5,023.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,716,521.2	0.0	14,716,521.2
9	Тайлант үеийн үр дүн	1,890,207.2	0.0	1,890,207.2
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,606,728.4	0.0	16,606,728.4
11	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	16,606,728.4	0.0	16,606,728.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,606,728.4	0.0	16,606,728.4
19	Тайлант үеийн үр дүн	218,351.1	0.0	218,351.1
20	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,825,079.5	0.0	16,825,079.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156,041,207.90	151,706,141.61	(4,335,066.29)	97.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,041,207.90	151,706,141.61	(4,335,066.29)	97.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,492,473.40	1,362,207.80	(130,265.60)	91.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,213,431.00	1,106,921.40	(106,509.60)	91.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,274.10	138,819.09	(13,455.01)	91.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,182.20	31,434.01	(1,748.19)	94.73
2104	Хангамж, бараа материалын зардал	46,385.40	39,327.04	(7,058.36)	84.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,220.40	1,220.00	(0.40)	99.97
2107	Томилолт, зочны зардал	15,853.20	15,811.60	(41.60)	99.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,227.10	26,776.16	(1,450.94)	94.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.00	1,898.50	(1.5)	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,548,734.50	150,343,933.81	(4,204,800.69)	97.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	154,548,734.50	150,343,933.81	(4,204,800.69)	97.28
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	156,041,207.90	64,285,264.39	(91,755,943.51)	41.20
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,518,786.90	21,518,786.90	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,522,421.00	42,705,088.81	(91,817,332.19)	31.75
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	61,388.68	61,388.68	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	11,673,342.80	11,673,342.80	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	14,190,483.53	14,190,483.53	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.10	0.10		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	47.00		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52.00	47.00		
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	47.00	42.00		

Э-тайланд

шивэхдээ НДЕГ-аас олгосон санхүүжилтийг орлогоор хүлээн зөвшөөрөхгүйгээр Мөнгөн гүйлгээний тайлан, "Төсвийн тохируулга" тайланд тохируулгын орлого, зарлагын зөрүү гэж тайлагнасан байна.<sup>1</sup>

Бодлогын баримт бичигийн 7.7-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөн гүйлгээний тайланд тохируулга хийнэ" ...7.7.2- Дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалтын зардлаас хуваарилагдсан санхүүжилт, түүний зарцуулалтыг тухайн санхүүжилтийн орлогоос зардлыг хассан дүнгээр тохируулна.



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах чиг үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлэлт, тайлагналыг цахимжуулах

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь тайлант онд Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Нийгмийн даатгалын Ерөнхий хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхлэхээр шинэчлэгдэн батлагдсан байна.
2. нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай /шинэчилсэн найруулга/
3. нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай /шинэчилсэн найруулга/
4. нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2018 оны 02 сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалаар Хяналт шалгалт, Дотоод аудитын тасгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тасгийн дарга нь, дотоод аудитор байхаар томилсон байна.

Дотоод хяналтын ажлын тасаг нь 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд ашиглагдах эрхийн актын хэрэгжилт, өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хамгаалалт, нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод аудитаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа НДЕГ-ын даргын 2018 оны А/64 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,098.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,673.4	14,190.5	2,517.1
Авлага	4,566.7	3,182.5	(1384.2)
Бараа материал	15.9	33.6	17.7
Үндсэн хөрөнгө	588.9	536.5	(52.4)
Нийт хөрөнгө	16,844.9	17,943.1	1,098.2
Өр төлбөр	238.2	1,118.0	879.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,606.7	16,825.1	218.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	16,844.9	17,943.1	1,098.2

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Нийгмийн Даатгалын газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс, бараа материал данс нэмэгдэж, авлага, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,517.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төрийн албан хаагчдын цалин хөлсний орлого нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг задалж харуулбал:
  - Үйл ажиллагааны дансны үлдэгдэл 0,01 сая төгрөг
  - Нийгмийн даатгалын сангийн Төвлөрсөн харилцах дансны үлдэгдэл 113.4 сая төгрөг
  - Тэтгэврийн дансны 13,507.8 сая төгрөг
  - Тэтгэмжийн даатгалын дансны үлдэгдэл 379.3 сая төгрөг
  - ЭМД-ын дансны үлдэгдэл 1.2 сая төгрөг
  - ҮОМШӨ-ний даатгалын данс 70.0 сая төгрөг
  - Ажилгүйдлийн даатгалын данс 118.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2018 оны А/51, 2023 оны А/170 тоот тушаалын дагуу мөнгөн хөрөнгийн урсгалыг дараа сарын зарлагын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 100 хувь нөөцтэй байхаар эрх зүйн зохицуулалттай байна.

2. Авлага 1,384.2 сая төгрөгөөр буурсан нь Өмнөх оны улсын төсвийн санхүүжилтийн авлага буюу цар тахлын үеийн НДШ-ийн чөлөөлөлттэй холбоотой авлага 1,854.0 сая төгрөг барагдсантай холбоотой байна. Авлагын эцсийн үлдэгдэлд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1,540.6 сая төгрөг, Улсын төсвийн санхүүжилтийн авлага 1,422.6 сая төгрөг, бусад авлага 211.9 сая төгрөг, НДШ-н алданги, торгуулийн авлага 7.4 сая төгрөг тус тус эзэлж байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл 17.7 сая төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн дагуу байгууллагын нэршил өөрчлөгдөх болсонтой холбоотой үйлчилгээний заал, сургалтын танхимыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан стандартын дагуу тохижилт хийгдсэн болно.
4. Өмнөх оноос үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 52.4 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тушаал болон нийгмийн даатгалын ерөнхий газрын тушаалаар 1.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 15,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэ тогтоосонтой холбоотойгоор буурсан байна.
5. Тайлант онд өр төлбөр данс нь 879.9 сая төгрөгөөр өсөж, 1,118.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүнд: Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 13.8 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 123.4 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн өглөг 167.7 сая төгрөг, оршуулгын тэтгэмж 2.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний ХЧТА-ны тэтгэмжийн өглөг, Урьдчилж төлсөн шимтгэлийн өглөг 757.7 сая төгрөг, бусад өглөг 51.7 сая төгрөг тус тус нөлөөлсөн байна.

### Орлогын данс

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 164,879.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 17,482.0 сая төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна.

#### Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого /НДШ-ийн орлого/Сан/	40,592.7	51,939.1	11,346.4	127.9
Татварын бус орлого /Сан/	165.6	183.4	17.8	110.7
Татварын бус орлого/ Үйл ажиллагаа/	10.9	4.2	(6.7)	38.5
Тусламж санхүүжилтийн орлого /Сан/	105,640.1	111,133.5	5,493.4	105.2
Тусламж санхүүжилтийн орлого /ҮА/	988.5	1,619.7	826.8	163.8
<b>Үйл ажиллагааны орлого дүн</b>	<b>147,397.8</b>	<b>164,879.9</b>	<b>17,482.1</b>	<b>111.9</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт орлогын дүн өмнөх оноос 17,482.1 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь Засгийн газрын тогтоолоор Төрийн албан хаагчдын цалин хөлсний орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

### Зардлын данс

Тайлант онд Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 164,661.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 19,153.9 сая төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал /Сан/	144547,3	163,003.4	18,456.1	112.8
Үйл ажиллагааны зардал /ҮА/	960,3	1,658.1	697.8	172.7
Үйл ажиллагааны бус зардал	0	0	0	0
<b>Үйл ажиллагааны зарлага дүн</b>	<b>145,507.6</b>	<b>164,661.5</b>	<b>19,153.9</b>	<b>113.2</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
----------	----------	------------	-------	------

Үйл ажиллагааны зардал	145,507.6	164,661.5	19,153.9	113.2
Үйл ажиллагааны бүс зардал	0	0	0	0
<b>Үйл ажиллагааны зарлага дүн</b>	<b>145,507.6</b>	<b>164,661.5</b>	<b>19,153.9</b>	<b>113.2</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Үйл ажиллагааны нийт зардлын дүн тайлант онд 19,153.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тэтгэврийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд сумдад өгсөн санхүүжилт төвлөрүүлэлтийн дүнгээр нэгтгэсэн тайланд 98,390.6 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг тус тус устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төсөл, төсөөллийн саналыг аргачлалын дагуу үнэн зөв бодит тооцоонд тулгуурлаж боловсруулах, хугацаанд нь нэгтгүүлэх, хариуцлагатай хандах зорилгоор хэлтсийн даргын 2023 оны № 18 тоот тушаалаар ажлын хэсэг томилж, сангийн орлогын төслийг 40,207.1 сая төгрөг, сангийн зардлын төслийг 148,100.0 сая төгрөгөөр төсвийн төслийг боловсруулж 2023 оны 07 сарын 01-ний дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажиллалаа.

Тайлант онд Нийгмийн даатгалын сан болон байгууллагын үйл ажиллагааны төсөв дараахь байдлаар тус тус батлагдсан байна.

Хүснэгт №4: Орлого, зарлагын төсөв /сая төгрөг/

ДД	Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгол хийсэн	Шийдвэр
1.	-Нийгмийн даатгалын сангийн зарлага /Сан/ -НДШ-ийн орлого -Улсын төсвийн санхүүжилт - Байгууллагын үйл ажиллагааны зардал /ҮА/	146,233.0 40,058.7 18,689.6 1,304.2	- - - -	НДЕГ-ын даргын 2023 оны 01 сарын 10-ны өдрийн А/04 тоот тушаал
2.	-Нийгмийн даатгалын сангийн зарлага /Сан/ -НДШ-ийн орлого -Улсын төсвийн санхүүжилт - Байгууллагын үйл ажиллагааны зардал /ҮА/		9,779.7 7,384.7 8,239.9 281.3	НДЕГ-ын даргын 2023 оны 07 сарын 07-ны өдрийн А/105 тоот тушаал
3.	-Нийгмийн даатгалын сангийн зарлага /Сан/ -НДШ-ийн орлого -Улсын төсвийн санхүүжилт - Байгууллагын үйл ажиллагааны зардал /ҮА/		- - (5,410.7) 29.9	НДЕГ-ын даргын 2023 оны 12 сарын 22-ны өдрийн А/182 тоот тушаал
ДҮН	Нийгмийн даатгалын сангийн зарлага /Сан/ -НДШ-ийн орлого -Улсын төсвийн санхүүжилт - Байгууллагын үйл ажиллагааны зардал /ҮА/		156,012.7 47,443.4 21,518.8 1,615.4	

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд төсөвт 3 удаа нэмэх тодотгол хийж, анх батлагдсан төлөвлөгөөнөөс Нийгмийн даатгалын сангийн зарлагыг 9,779.7 сая төгрөгөөр, НДШ-ийн орлогыг 7,384.7 сая төгрөгөөр, улсын төсвийн санхүүжилтийг 2,829.2 сая төгрөгөөр, байгууллагын үйл ажиллагааны зардлыг 311.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

#### Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт.

НДШ-ийн шимтгэлийн орлогыг 2023 оны жилийн эцсээр 68,962.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 64,285.3 сая төгрөгийг төвлөрүүлж 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрөл тус бүрээр дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл	22,315.2	20324.0	(1,991.3)	91.0
Ажиллагсдаас төлсөн шимтгэл	18,395.6	17367.0	(1,028.7)	94.4

Цаатан иргэдийн шимтгэл	172.1	141.6	(30.6)	82.2
Сайн дурын даатгуулагчаас телсен шимтгэл	5,564.3	4480.5	(1,083.8)	80.5
Эхийн хvvхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас телех шимтгэл	270.3	121.9	(148.4)	45.1
Эхийн хvvхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс телех шимтгэл	306.9	179.0	(128.0)	58.3
VOMШЕДС-аас телсен шимтгэл	34.0	25.5	(8.5)	75.0
Бусад орлого	384.8	127.0	(257.8)	33.0
Улсын төсөв	21,518.8	21,518.8	-	100.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>68,962.2</b>	<b>64,285.3</b>	<b>(4,677.0)</b>	<b>93.2</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

### Төсвийн зарлагын талаар:

Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага 2023 оны жилийн эцсээр 156,041.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 150,306.4 сая төгрөг зарцуулж, байгууллагын үйл ажиллагаанд 1,615.4 сая төгрөг зарцуулж, нийт гүйцэтгэл 97.2 хувьтай байна.

2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийг харуулбал: /сая.төгрөгөөр/

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	147,924.7	144,267.1	3,657.6	97.53
Тэтгэмжийн даатгалын сан	4,952.8	4,556.7	396.0	92.00
VOMШЕ-ний даатгалын сан	590.1	525.6	64.5	89.07
Ажилгvйдлийн даатгалын сан	958.3	956.9	1.3	100.00
Үйл ажиллагааны зардалд зарцуулсан	1,615.4	1,399.7	215.6	87.00
<b>Дүн</b>	<b>156,041.2</b>	<b>151,706.1</b>	<b>(4,335.1)</b>	<b>97.22</b>

Тайлант онд батлагдсан төсвийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн олгож зардлын ангилал хооронд хэтрүүлэн зарцуулаагүй байна.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд гадаад, дотоодын эх үүсвэрээр төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр хийж, дараагийн шатны хяналтыг дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2024 оны 01 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 2,947.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,328.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант оны үйл ажиллагааны зардлын дүн, Нийгмийн Даатгалын сангийн зарлагын дүн өссөн тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг аудитын явцад материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад зөрчилтэй асуудал илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үйл ажиллагааны тайланд аудит хийж, 8,000.0 мянган төгрөгийн 3 залруулга хийж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Нийгмийн даатгалын сангийн тайлан болон байгууллагын үйл ажиллагааны тайланг гаргаж нэгтгэсэн байна.

Аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### Залруулсан алдааны талаар:

- Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Хөвсгөл аймгийн Нийгмийн Даатгалын газрын зөрчлийн талаар:

Хөвсгөл аймгийн Нийгмийн Даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Нийгмийн Даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй болно.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн